



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар Д/430

Хэрлэн сум


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ийн 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Батширээт сумын харьяат Пүрэвийн Бат-Эрдэнэ нь Казакстан улсад болох Гар барилдааны спортоор дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцоход нь 500,000 (таван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ